

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА,
САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2013 оны 02 дугаар
сарын 14-ны өдөр

Дугаар 33/37

Улаанбаатар хот

**Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа
даатгагч бүрээс төвлөрүүлэх хөрөнгийн
хэмжээг тогтоох тухай**

Жолоочийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий даатгагч бүрээс Жолоочийн даатгалын санд 2013 онд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг тухайн даатгагчийн 2012 оны жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамжийн нийт орлогын 3 хувиар тогтоосугай.

2.Дээрх мөнгөн хөрөнгийг Жолоочийн даатгалын санд 2013 оны 02 дугаар сард багтаан төвлөрүүлэхийг Албан журмын даатгагчдын холбоо /Д.Цэвээнжав/-нд даалгасугай.

3.Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА**

Д.БАЯРСАЙХАН

САНГИЙН САЙД

Ч.УЛААН